

STUDIA FOLCLORICA

FOLKLORE STUDIES

<https://doi.org/10.5564/sf.v45i1.4823>

Tom. XLV

2024

fasc. 14

Монголын нууц товчоон дахь эртний монголчуудын соёлын уламжлал

Сэржээгийн МӨНХСАЙХАН*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн

Хэл шинжлэлийн салбар

Received: Jun 17, 2024

Revised: Jul 18, 2024

Accepted: Aug, 23, 2024

Хураангуй: Монголын нууц товчоо хэдийгээр дундад зууны монголчуудын төрт улсаа байгуулсан түүхэн үйл явдлыг тэмдэглэн үлдээсэн төрийн түүх боловч түүнд эртний монголчуудын соёлтой холбоотой олон баримт хадгалагдан байдаг. Үүнийг бид эртний монголчуудын аман соёл, харилцааны соёл, ураг хуримын соёл, шашин шүтлэгийн соёл хэмээн хуваан тус бүрд нь судалж үзэв. Судалгааг дүгнэн үзвэл, эртний монголчуудын бүтээн бий болгосон соёл, ёс заншил нь эртнээс нааш уламжлагдан ирж, нийгмийн харилцааг эмх цэгцтэй, дэг журамтай болгодог бичигдээгүй журам байжээ. Өөрөөр хэлбэл, эртний монголчуудын соёлоор дамжсан дадал зуршил нь нийгмийн харилцаа болоод өдөр тутмын амьдралыг эмх журамтай болгож, тэрхүү өдөр тутмын амьдралын дадал хэвшилээр дамжуулан хүнийг хүмүүжүүлэн төлөвшүүлэх, ёс суртахуун, харилцааны хандлагад сургадаг, товчоор хэлбэл хүнийг “хүн” болгодог гол зүйл байжээ.

Түлхүүр үг: Монголын нууц товчоо, аман соёл, харилцааны соёл, ураг хуримын соёл, шашин шүтлэгийн соёл

Cultural tradition of ancient Mongols in the Secret History of the Mongols

MUNKHSAIKHAN Serjee

Department of the Linguistics, Institute of Language and Literature,

Mongolian Academy of Sciences, Mongolia

Abstract: The Secret History of the Mongols contains extensive evidence of Mongolian customs and cultural practices. These findings suggest that oral traditions—

* © С.Мөнхсайхан

Email: munkhsaikhans@mas.ac.mn

such as “oral decrees”, “oral news”, “oral agreements”, “oral oaths”, and “oral lessons”—played a significant role in society. Such traditions were essential cultural pillars that embodied values of integrity, upbringing, and courage. This is reflected in the medieval Mongolian saying, “Don’t Mongols have an oath of ‘za’ (meaning ‘yes’)?” Additionally, sections detailing wedding customs, which have been passed down since ancient times, provide valuable insights. Traditions such as betrothal, formally requesting a bride’s hand in marriage, taking a wife, and granting a daughter in marriage as an honor were not merely aspects of population planning. Rather, they served as mechanisms for maintaining social harmony and ensuring peaceful coexistence. Similarly, the study suggests that Mongolian customs played a fundamental role in structuring and regulating social relations in an orderly manner. Regarding mentalities, the foundation of Mongol unity in consciousness and worldview lay in their shared belief in “Munkh Tenger (the Eternal Sky)” and shamanistic customs dedicated to nature. This was not merely a religious transformation but also a profound shift in the way medieval Mongols perceived and understood the world.

Key word: Secret History of the Mongols, culture, ancient Mongols, ritual

Аливаа үндэстний соёл ард түмний өдөр тутмын ахуй амьдралаар уламжлагдан ирэхийн хамт бас хэлэндээ шингэж, үндэстний сэтгэлгээний онцлогийг тодорхойлж байдаг. Тиймээс хэл бол үндэстний соёлын орших, илрэх бас нэгэн хэлбэр болдог. Нөгөө талаар хэл өөрөө үндэстний соёлын нэгэн төрөл юм. Учир нь, хэл бол нийгмийн харилцаа болон хүний үйлдлийг тодорхойлогч, мөн өөрчлөгч, юм үзэгдэлд өгч буй үнэлгээ байдаг.

Соёл гэсэн ойлголтод ард түмний өвөрмөц зан үйл, уламжлалт ёс заншил, ахуй амьдралыг оруулахаас гадна үндэстний өвөрмөц сэтгэлгээ (сэтгэл зүй), гүн ухаан (ертөнцийг үзэх үзэл), угсаатны шинжлэл (угсаатны бүрэлдэхүүн, онцлог) гэх мэт олон хүчин зүйлийг холбон үздэг. Харин хэл соёлын шүтэлцээг “Түүхэн цаг хугацааны явцад ард түмний хэвшин тогтсон амьдралын хэв маяг хэлэндээ загварчлагдан шингэх бөгөөд хэлний ийм баримт нь эргээд тухайн түүхэн цаг үеийн хүмүүсийн амьдралын хэв маяг, ёс заншил, сэтгэлгээний онцлогийг тодруулах хэрэгсэл болдог” (Нансалмаа, 2015: 51) гэж тодорхойлжээ. Монголын нууц товчоонд эртний монголчуудын өвөрмөц соёлын тухай олон сонирхолтой баримт байдаг. Үүнээс XIII-XIV зууны монголын нийгмийн харилцаа, нийгмийн үнэт зүйлийг тодорхойлж буй дараах хэдэн зүйлийн баримтыг онцлон танилцуулъя. Үүнд:

1. Монголын нууц товчоон дахь аман соёл
2. Монголын нууц товчоон дахь харилцааны соёл
3. Монголын нууц товчоон дахь ураг хуримын соёл
4. Монголын нууц товчоон дахь шашин шүтлэгийн соёл болно.

Монголын нууц товчоон дахь аман соёл. Монголын нууц товчоонд эртний монголчуудын аман соёлд холбогдох олон баримт бий. Тухайлбал, зохиолын бараг зүйл бүрд “амаар зарлиг болсон”, “амаар өгүүлж илгээсэн”, “амаар өчсөн”, “аман тангараг тавьсан”, “амыг нь асуусан” тухай өгүүлдэг.

Түүхэн сурвалжийн баримтаар Чингис хаан Их Монгол Улсыг байгуулах тэр цагт олон монгол овог аймгийн аж ахуй, соёлын түвшин харилцан адилгүй, түүнийгээ дагаад зарим овог аймаг үсэг бичигтэй, зарим нь үсэг бичиггүй байсан ба Их Монгол Улс байгуулагдсанаар нэгдмэл бичгийн хэлний хэрэгцээ бий болсон байдаг. Өөрөөр хэлбэл, монголчуудын өнгөрсөн түүхийг сөхөж үзвэл улс гүрэн хүчирхэгжин мандахыг даган соёл, үсэг бичгийн хөгжил эрчимжсэн байдаг. Энэ нь улс үндэстэн хүчирхэгжвэл өөрийн үнэт зүйл, соёлоор бахархах үзэл хүчтэй болж, тэр хэрээр бусад улс үндэстэнд нөлөөлдөг ажээ. Үндэстний бахархал омогшил ид хүчтэй байсан ийм түүхэн цаг үед уйгуржин монгол бичиг нь аль нэг овог аймгийн тодорхой хүмүүсийн хүрээнд хэрэглэгдэж байсан, тэр овог аймгийн хүмүүсийн олон зууны жилийн өмнөх ярианы хэлний байдлыг тусгасан байв. Олон монгол угсаатан (есөн хэлтэн иргэн) өөр өөрийн хэл аялгууны онцлог бүхий нутгийн аялгуугаар ярилцах хэдий ч бүх нутгийн аялгууны онцлогийг шингээсэн үсэг бичиг хараахан байсангүй. Үсэг бичгийн хөгжил ийм байсан учир энэ үед эртнээс уламжилж ирсэн аман соёл, аман харилцаа хүчтэй байсан нь Монголын нууц товчоонд гарах олон жишээнээс харагддаг. Жишээ нь, зохиолын 53-р зүйлд Амбагай хаан татаруудад баригдан Хитадын Алтан ханд хүргэгдэхдээ

-Арван хөвүүдийн дотор Хадаан тайшид өгүүл хэмээн өгүүлж илээрүүн: -Хамгийн хаан улсын эзэн болж охиноо өөсөн үдэхүйгээ намаар гэсээдхүн. Татар иргэнээ баригдаа би.

Таван хуруудаа химул тамтал

Арван хуруудаа уудтал

Ач мину авран соридхун хэмээж илээжээ.

гэдэг. Өөрөөр хэлбэл, энэ бол Амбагай хаан Балахачи элчээр дамжуулан “Татаруудад баригдсан өсийг минь заавал аваарай” хэмээн захисан аман зарлиг бүхий гэрээс юм. Хэдийгээр Амбагай хаан алагдсан боловч хааны зарлиг болгосон гэрээсийг заавал биелүүлэх учиртайг

-Хутула хаан болоод Хадаан тайш хоёр Татар иргэнд морилов. Татарын Хөтөн бараха Жали буха хоёрт арван гурвантаа хатгалдаж Амбагай хааны өсөл өсөн хясал хясан ядав [58§].

гэж өгүүлсэн үйл явдлаас харж болно. Тэрчлэн Монголын нууц товчоонд “зарлиг” гэдэг үг нийт 162 удаа гарах ба үүнээс бараг 90 орчим хувь нь “зарлиг болох” гэдэг холбоо үг байна. Хаан зарлигаа амаар хэлдэг байсныг

-Бас хэшигүүдийн өтгөс гутгаар гутгаар хэшиг орохуйд егүүтгэлдэхүйд энэ зарлиг хэшигтэнээ сонсготугай. Зарлиг сонсоод бүрүүн хэшигтэн хэшиг оорвоос зарлигийн ёсоор эрүүлэе [278§].

гэсэн жишээнээс мэдэгдэж байна. Үүнээс үзвэл Их хаан зарлигаа амаар өгүүлэх ба түүнийг түгээн уламжлахыг “зарлиг тунхах”, “зарлиг тунхаах” гэдэг байв. Уул холбоо үгийн үйл үг нь “амаар зарлан мэдээлэх” гэсэн утгатай зарлагийг амаар зарлан уламжилдаг байжээ. Энэ мэтчилэн Чингис хаан зарлигаа амаар хэлдэг, түүнийг хатуу чанд сахин биелүүлдэг байсан нь дундад зууны үед аман харилцаа хэчнээн хүчтэй, нөлөөтэй байсныг илтгэнэ. Ийм учраас дундад зууны

монголчууд хэлсэн үгэндээ хүрдэг хүний зан чанарыг хамгийн ихээр үнэлдэг байжээ.

Үүний адил элч илгээхдээ элчийн аманд буй мэдээнээс шалтгаалан “өгүүлж илээх” [105§, 106§, 110§, 127§, 167§, 170§, 183§, 190§, 194§, 196§, 238§, 256§, 276§, 279§], “хэллэж илээх” [105§, 133§, 194§], “өчиж илээх” [238§, 258§, 275§], “дуу бариулж илээх” [181§, 265§] гэх мэтээр ялгажээ. Жишээнээс үзвэл “өгүүлж илээх” нь “өөрийн бодсон санасан зүйлээ учирлан тайлбарлаж, амаар илтгэх” бол “хэллэж илээх” нь адилхан амаар өгүүлэхийн зэрэгцээ “хэрэг юмны учрыг тайлбарлан ярих” гэсэн утгын ялгаатай. “Өчиж илээх” нь өөрөөс албан тушаал, зэрэг дэв өндөр хүнд “айлтган хэлж явуулах” гэсэн утгатай. “Дуу бариулж илээх” нь “хол зайд аман мэдээ дамжуулах” гэх мэтээр тус тусдаа утгын ялгаатай хэллэгүүд юм. Монголын нууц товчоонд гарч буй аман харилцаатай холбогдох дээрх үгс нь утгын ийм ялгаатай, хэнд, ямар мэдээ хүргэхээс шалтгаалан үгийн хэрэглээ өөр байна. Ерөөс Монголын нууц товчоонд аман соёлын ийм нарийн ялгааг хэлээр илэрхийлж буй нь дундад зууны монголчуудын дунд аман соёл хэр нөлөөтэй байсныг илтгэнэ. Иймээс монгол ардын үгэнд “Элчийн үг аманд буй” гэдэг хэллэг бий болжээ.

Монголын нууц товчоонд өгүүлж буй аман соёлын хамгийн чухал баримт бол “үг баралдаж аман алдах” буюу “аман тангараг тавих” ёс юм. Энэ тухай 123-р зүйлд

-Алтан, Хучар, Сача бэхи бүрүүн эетэлдэж Тэмүжинээ өгүүлрүүн: -Чамайг хан болгоё. Тэмүжинийг хан болбоос ба (бид)

Олон дайнд алгинч уулж

Өнгө сайн охин хатан, орд гэр

Харь иргэний хацар гоо хатан охин

Харгам сайн агт хатируулж авчирч өгсү ба (бид)

Ороо гөрөөс авлаваас ударч өгсү ба (бид)

Хээрийн гөрөөсний хэвэл инү нэгтэл шахаж өгсү

Гууны гөрөөсний гуя ину нэгтэл шахаж өгсү ба (бид)

Хатгалдахуй өдөр хал чину буш болговоос

Харь ширидээс (ширээс)

Хатан эмдээс (эмээс) ману хагацуулж

Хар тэрүүн ману газар хөсөрт гэж од.

Энх өдөр эе чинү эвдвээс

Эрс ардаас, эм хөвүүдээс ману ирчүүлж

Эзгүй газраа гэж од.

Эдүй үг баралдаж ийн ам алдаж Тэмүжинийг Чингис хаан хэмээн нэрийдэж хан болгов [123§].

гэж өгүүлдэг. Өөрөөр хэлбэл, Алтан, Хучар, Сача бэхи нар санаа нэгдэн Тэмүжинийг хаан болгож түүнд хүчин зүтгэхээр аман тангараг өгдөг. Гэвч хожим тэд хэлсэн үгэндээ хүрээгүй тухай 136-р зүйлд

-Барьж Чингис хаан Сача Тайчу хоёроо өгүүлрүүн: -Эрт өдөр бид юу хэмээлдээ хэмээгдэж Сача, Тайчу өгүүлрүүн: -Өгүүлсэн үгэндээ

ба (бид) эс хүрвэй. Үгст ману хүргэ хэмээгээд үгсээ мэдэрч түшиж өгвэй. Үгсийг ану мэдрүүлж үгст ану хүргэн бүтээж, мөн тэнд гээвэй гэх мэтээр өгүүлж буй нь үйл хэрэгт хамтрахаар шийдсэн хүмүүс хэлэлцэж ярилцан “үг баралдан” аман тангараг өгдөг, хэрэв хэлсэн үгэндээ үл хүрвэл “алах” хатуу шийтгэлтэй тул түүнийгээ заавал биелүүлдэг байжээ. Энэ цагт нийгэм ороо бусгаа, хатуу ширүүн тэмцэл тулаантай байсан тул хэлсэн үгэндээ хүрэх эсэх нь хүний мөн чанарыг харуулаад зогсохгүй хэрэг явдлын үр дүнг ч өөрчлөх эрсдэлтэй тул дундад зууны монголчууд **Монгол “Зэ андгартан” бусад уу** [108§] гэдэг “аман хууль”-тай байв. Энэ нь Монголчууд “за” гэж зөвшөөрсөн бол хэлсэндээ заавал хүрдэг гэсэн утгатай. Хэрэв үгэндээ хүрэхгүй бол “Зэ-дээс хожидсоныг зэрэгдээс гаргая” [108§] гэдэг. Мөн хэлсэн амандаа хүрэхээ илэрхийлэхдээ

-“Зэ”-ийн нөхөр
Зээрдийн минаа болж
“Зэ”-дээс үл хождон
Зэргэдээс үл цолойдон [255§]

гэх мэтээр хэлдэг байжээ. Өөрөөр хэлбэл, “зэ” гэсэн бол хэлсэндээ хүрдэг хүнийг (“зэ”-ийн нөхөр), “зэ” гэсэн бол ямар ч нөхцөлд болзоондоо байх (“зэ”-дээс үл хождон) амлалт өгдөг байжээ. Энэ бол дундад зууны монгол хүний мөс чанар, хүмүүжил, ёс суртахууныг илэрхийлсэн аман соёлын маш чухал баримт юм. Түүнчлэн ам тангараг өгөх олон янзын зан үйлийн тухай

-Жажирдай Жамуха-ыг хан өргөө хэмээн азарга гүү хэгүс цавчлалдаж андагалдаж [141§]

-Эдүгээ хөвүүнээ үзэж муу сэтгэвээс энэ мэт цусаа гаргагдсу хэмээн андгаж шиги хуруу юугаа толь оновч хутгаар хатгаж цус цувируулж өчүүхэн дахтайд хийж “Хөвүүнээ минү өг” хэмээж илээв [178§]

гэж өгүүлснээс үзвэл андгай тангараг нь жирийн нэг зан үйл бус гэдгийг “цус гарган баталж” буйгаар илэрч байна.

Үүнээс гадна дундад зууны монголчууд үр хүүхдээ бас амаар сургаж хүмүүжүүлдэг байсан тухай Монголын нууц товчоонд олонтоо өгүүлдэг. Ийм үгийг сүюгэр үг гэнэ. Тухайлбал, Алан гоо эх

-Бас Алангоо таван хөвүүддээ сүюгэр үг өгүүлрүүн: -Та таван хөвүүд минү гагц хэвлээс төрөв. Та тугаарын таван мөсөд мэт гагц гагц болбоос тэр нэжгээл мөсөд мэт хэнээ бээр хялбараа хугалдахун та. Тэр цугтай мөсөд мэт хамт нэгэн эетэн болбоос хэнээ бээр хялбараа яахан болохун та хэмээби. [22§]

Мөн Чингис хаан Жочи, Цагаадай, Өгэдэй гурван хөвүүдээ

Байсан газраа багта[н] алдтал
Манлайн хөлс арчин ядтал бадархийж чамраар сүюгэр дуулган
[260§]

хэлсэн тухай, 277-р зүйлд Өгэдэй хаан Гүюгт сүюгэр үг донгодсон тухай өгүүлдэг. Ингэхдээ хуучны үгээс үндэслэн, өвгөдийн үгээс эш татаж буюу

Өтгөс үгс орхидож

Хуучин үгс хадалж [277§]

сургадаг учир “аман билигт ард түмэн” хэмээн нэрлэсэн нь ийм учиртай.

Ийнхүү дундад зууны монголчуудын дунд аман соёлын нөлөө маш хүчтэй байсныг “аман зарлиг”, “аман гэрээс”, “аман мэдээ”, “аман тангараг”, “аман хууль”, “аман сургамж”-ийн зүйлүүд харуулах бөгөөд энэхүү боловсронгуй аман соёлын хөгжил нь Монголын нууц товчоог анх амаар зохиож хожим бичигт тэмдэглэсэн байж болохыг батлан харуулж байна.

Монголын нууц товчоон дахь харилцааны соёл. Хүний нийгэм бүхэлдээ хүн хоорондын харилцаанд тулгуурладаг. Энэ харилцаа нийгмийн бүтэц, хүмүүсийн боловсрол мэдлэг, соёл, танин мэдэхүйн чадвар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан нийгмийн цаг үе бүрд адилгүй байжээ. Тухайлбал, дундад зууны монголын нийгмийн харилцааны соёлыг илтгэсэн баримт Монголын нууц товчоонд хадгалагдан байдаг. Тухайлбал, Монголын нууц товчооны 33-р зүйлд буюу зохиолын эхэнд

-Бодончар Буху хатаги ах юугаа хойноос дагаж хатирч яв[ан]

өгүүлрүүн: -Ах ах, “**биет тэрүүт дээл захт сайн**” хэмээв.

гэж Бодончарын хэлсэн үг нь монголчуудын, тэр дундаа дундад зууны монголчуудын нийгмийн үзэл санаа гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, нийгмийн амьдралд зайлшгүй удирдан манлайлагч байх ёстой ба тэр ард түмнийг удирдан дагуулах үүрэгтэй. Иймээс энэ агуу их үйл хэргийг Чингис хааны дээд өвөг Бодончар ах дүү нарын хамт эхлүүлж Чингис хааны үед бүх монгол овог аймгийг нэгтгэн цуглуулж Монголжин улсыг жившээрсэн нь Монголын нууц товчооны гол үзэл санаа юм. Бодончарын хэлснээр хэрэв ард түмэн “их өчүүхэн, муу сайн, тэрүү шийр үгүйн сацуун” бол “хялбар иргэн” буюу “дайлан эзлэхэд хялбар” болдог ажээ. Тиймээс ихэс дээдэс болоод түүний харьяат албат, цэрэг иргэний харилцааг тодорхой хууль дүрмээр зохицуулдаг бол хүн ёсны харилцааг эртний монголчуудын дунд хэвшин тогтсон дадал, ёс зүй, уламжлалт зан үйл тодорхойлж байв.

Дундад зууны монголчуудын харилцааны соёлын хамгийн шилдэг жишээ нь Монголын нууц товчоон дахь “эцэг хүү хэмээх ёсон”, “анд хэмээх ёсон”, “ирж нөхөрлөсөн ёсон”-ы тухай үлгэр түүх юм. Монголын нууц товчоонд өгүүлснээр Есүхэй баатар Ван хан нарыг анд бололцсон тухай

-Хэрэйдийн Ван хаан бүрүүн, урьд Есүхэй ханы цагт сайнаар эл алдсанд Есүхэй хан лугаа анд хэмээлдсэн ажгуу. Анд хэмээлдэхүй ёсон ину Ван хан эцэг юүгээ Хурчахус буйруг ханы дүү нэрээ алахын тул Гүр хан авгатайгаа булха бололцож Харагун хавцал шургуулдаж зуун хүмүүн гарч Есүхэй ханд ирвээс Есүхэй имайг өөртөө ирэгдэж өөсөн (өөрөө) цэрэг морилж Гүр ханыг Хашин зүг үлдэж иргэн оргон ину Ван ханаа авч өгсний тул анд бололцох тэр [150§].

гэж өгүүлдэг. Ийнхүү эцэгтэй нь анд хэмээлдсэн учир “эцэг мэт буюу” хэмээгээд

-Эцэг лүгээ минү анд хэмээлдсэн эцэг мэт буй зэ хэмээн Ван ханыг Туулын Хар түнээ буюу хэмээн мэдэж одов. Ван ханд Тэмүжин хүрч өгүүлрүүн: -Эрт өдөр эцэг лүгээ минү анд хэмээлдсэн ажгуу. Эцэг-хүү мэт буюу зэ хэмээж гэргий буулж өмсгөл чамд авчрав хэмээн булган дах өгөв [96§].

хэмээн хүндэтгэн “дээлтэй төрсөн хөвүүн” болж улмаар “эцэг хөвүүн” болсон тухай

-Тэмүжин хөвүүнийг Сэнгүмийн ах болгож хоёр хөвүүт болж амуусугай хэмээж Чингис хаан лугаа Ван хан Туулын Хар түнээ хуриж эцэг хөвүүн хэмээлдвэй. Эцэг хөвүүн хэмээлдэхүй ёсон урьд эрт өдөр Есүхэй хан эцэг лүгээ Ван хан анд хэмээлдсэн ёсоор эцэг мэт хэмээж эцэг хөвүүн хэмээлдэхүй ёс тийм [164§].

гэж өгүүлсэн байдаг. Тэмүжин ийнхүү эцэгтэй нь анд хэмээлдсэн Ван хантай “эцэг хүү” болсон нь нэг талаар эцгийн үйл хэргийг үргэлжлүүлж буй мэт боловч нөгөө талаар улс төрийн хувьд найдвартай хамтрагчтай болж буй хэрэг юм. Энэ зан үйлийг баталгаажуулж буй “тамга” нь тэдний

-Олон дайсанд уулруун хамт нэгнээ уулъя
Ороо гөрөөсөнд авларуун нэгнээ-хүү хамт авлая
Шүдэт могойяа сүдэртвээс
Сүдэргэнд бүү орё
Шүдээр амаар өгүүлэлдэж бүширье.
Араат могойяа адартваас
Адарганыг ину бүү авалцъя
Амаар хэлээр ололцож бүширье [164§]

хэмээсэн аман тангаргийн үг юм. Энэ бол эртний монголчуудын ахмадаа хүндэтгэх, бие биеэ харилцан хүндэтгэх, итгэлцэн нөхөрлөх тангараг журмын үг билээ.

Түүнчлэн Монголын нууц товчоон дахь харилцааны соёлын хамгийн шилдэг үлгэр дуурайл бол Тэмүжин Жамуха нарын “анд хэмээлдсэн ёс” билээ. “Анд” хэмээх үгийг Германы эрдэмтэн Э.Хэйниш “тангаргийн нөхөрлөл, найз нар” (Haenisch, 1939: P7) гэж ойлгож орчуулсан нь уул үгийн утгыг нэлээн оновчтой илэрхийлжээ. Монголын нууц товчоо нь Чингис хааны тухай зохиол учир Тэмүжин, Жамуха хоёрын анд бололцсон түүхийг илүү дэлгэрэнгүй өгүүлжээ. Тухайлбал, 116-р зүйлд

-Анх урьд анд бололцруун, Тэмүжин арван нэгэн наст бүхүйд Жамуха гуралтуг шаа Тэжүжинээ өгч, Тэмүжиний чингүлтүгт шаа арилжиж анд бололцож анд хэмээлдсэн. Ононы мөсөнд шагалцахуйд тэнд анд хэмээлдлээ [116§].

-Түүний хойно хавар алангир нумтан харвиалдан бүхүйд, Жамуха бярууны хоёр эвэр нааж нүхэлж хийсэн дуут ёроо Тэмүжинээ өгч, Тэмүжиний арц манлайт годил арилжиж андчилалдвай. Нөгөөт анд хэмээлдсэн ёсон тийм [116§].

гэсэн бол, гурав дахь удаа анд болсноо бататгасан тухай 117-р зүйлд

-Эдүгээ бас анд тунхулдаж амаръя хэмээлдэж Тэмүжин Мэргидийн Тогтоуа-ыг арвилж авсан алтан бүс Жамуха андад бүслүүлбэй. Тогтога-ын эсгэл халиуныг Жамуха андад унуулбай. Жамуха Увас мэргидийн Дайр усуныг арвилж авсан алтан бүс Тэмүжин андад бүслүүлбэй. Дайр усуны хүү эвэрт үнэгэн цагааныг Тэмүжинээ унуулбай. Хорхонаг жубурын Хулдагар хуны өврөө саглагар модноо анд хэмээлдэж амралдаж, хуримлан тойлон жаргалдаж, шөнө хөнжилдөөн гагц хонолдохун бүлгээ.

гэж тус тус өгүүлдэг. Дээрх жишээнээс үзвэл, эхний хоёр хэсэгт Тэмүжин Жамуха хоёр “анд хэмээлдсэн буюу анд бололцсон” бол дараагийн хэсэгт “анд болсноо эргэн дурсаж (тунхулдаж), дахин бататгаж” буй тухай өгүүлжээ. Ингэхдээ тэд бага насандаа өөрсдийнх нь хувьд эрхэм байсан зүйлс (шагай, сум, годил)-ээ солилцсон бол насанд хүрсэн хойноо “тэдний нөхөрлөл хэвээрээ, түүнийгээ дахин баталъя, санаа зорилго нэгтэй гэдгээ дахин баталлаа” гэдгээ илэрхийлэн алтан бүс¹, морь солилцож байна. Үүнээс үзвэл эртний монголчууд “анд бололцох”-доо хоёр хүн өөрт үнэтэй зүйлээ харилцан солилцож, ёслол үйлддэг байжээ. Түүнчлэн “Анд” бол “андалдах” буюу солилцох гэдэг үгийн язгуур бөгөөд төрөл бус овгийн хүмүүс хоорондоо нөхөрлөх, харилцааны соёлын нэг илэрхийлэл юм. “Монголын нууц товчоо”-ны хятад орчуулгад “анд” гэдэг үгийг “契交” (тангаргийн нөхөрлөл) гэж орчуулсан нь санамсаргүй хэрэг биш юм. Учир нь, анд болж буй хүмүүс харилцан “аман тангараг өргөдөг” байсныг хятад хүмүүс “аман гэрээ” гэж ойлгосон байна. Өөрөөр хэлбэл, “анд” хүмүүс нь жирийн хүмүүс шиг нөхөрлөдөггүй “санаа сэтгэл нэгдэж амь нас, зорилго нэгтэй боллоо гэдгээ баталж ам тангараг өргөж, ёслол үйлддэг”-ийг мэддэг байснаас үүджээ. Тиймээс тэд “найз юм уу нөхөд” болсонгүй “анда 安荅 (an ta)” болсон байна. “Анд” ийм утгатай бол “андгартан”-ыг “бие биедээ аман тангараг өгсөн хүмүүс” гэж ойлгож болно. Үүнд мөн давхар солилцохын утга агуулагдах ба энэ нь “андгар” (амлалт)-ыг өөртөө бус, өөр хэн нэгэнд бус, “ангартан” болж буй хүмүүс бие биедээ өгснөөр илэрнэ.

Үүнээс үзвэл Монголын нууц товчоонд аман тангаргийн хоёр зүйл байна. Үүнд:

1. *Андгар (андгай) тангараг.* “Анд” буюу “солилцох” гэдэг үгээс үүссэн “андгар” гэдэг үгийн утгатай холбоотой. Иймээс хоёр хүн бие биедээ харилцан тангаргийн амлалт өгвөл “андгар тангараг” болно. Тухайлбал, 164-р зүйлд Ван хан, Тэмүжин нарын хэлэлцсэн үг нь андгай тангараг болно.

2. *Өчил тангараг.* Энэ нь хаан эзэн юм уу өөрийн эзэн ноёндoo үнэнч байхаа илэрхийлсэн амлалт юм. Тухайлбал, Алтан, Хучир нарын амлалтын үг юм.

Монголын нууц товчоонд бас хүний эр зориг, үнэнч сэтгэлийн илэрхийлэл болсон “ирж нөхөрлөх ёс”-ны тухай өгүүлсэн түүх бий. Монголын нууц товчоонд дурдсанаар хүүхдээ боол болгон нөхөрлүүлэх ёс нь нэг насны үнэнч

¹ Эртний Монголчуудын хувьд Алтан бүс эрх мэдлийг илэрхийлж байдаг.

журамт нөхөрлөл бөгөөд харин “ирж нөхөрлөх ёс” нь дайсан явсан хүний үнэнч зоригтой занг үнэлсэн түүх юм. Тухайлбал, Зэв Тайчуудаас ирж нөхөрлөсөн ёс, мөн Жирхиний хадаг баатрын ирсэн түүхийг үүнд дурдаж болно.

Монголын нууц товчоон дахь ураг хуримын соёл. Монголын нууц товчоонд дундад зууны монголчуудын ёс заншлаас хамгийн тодорхой тэмдэглэгдсэн нь ураг хуримын зан үйл билээ. Тухайлбал, зохиолын эхэнд

-Буйр нуур Хөлөн нуур хоёр зуур Уршуун мөрөнөө бүхүн Айригуд Буйругуд татар иргэнээ Амбагай хаан охин өгч, өөсөн (өөрөө) охиноо үдэж одох болон Татар Жүйн иргэн Амбагай хааныг барьж Хитадын Алтан ханаа авч одохуйд Амбагай хаан Бэсүдэй хүмүүн Балахачи элчээр өгүүлж илээрүүн, Хабул хааны долоон хөвүүдийн думдад Хутула-д өгүүлрүүн: -Арван хөвүүдийн дотор Хадаан тайшид өгүүл хэмээн өгүүлж илээрүүн: -Хамгийн хаан улсын эзэн болж охиноо өөсөн үдэхүйгээ намаар гэсээдхүн [53§].

хэмээн өгүүлсэн нь эртний монголчуудын ураг хуримын ёсонд эцэг нь охиноо хүргэдэг заншил байсны баримт бөгөөд Амбагай хаан охиноо хүргэж яваад Татаруудад баригдсанаар энэ заншлыг халсан байна. Тиймээс хожим

-Дэй сэцэн Тэмүжинийг үзэж маш их баясаж өгүүлрүүн: -Тайчууд ах дүү чинү найтму хэмээн мэдэж маш эрж цөхлөө. Аран үзэв зэ чамайг хэмээгээд Бөртэ үжинийг нийлүүлээд үүсгэв. Үүсгэн айсурун Дэй сэцэн зуур Хэрлэний Ураг цөл нугадаас (нугаас) харив. Гэргий инү Бөртэ үжиний эх Чотан нэртэй бүлий. Чотан охиноо үдэж Гүрэлгү дотор Сэнгүр горхиноо бүхүйд хүргэж ирэв [94§].

хэмээн Бөртэ үжинийг түүний эх Чотан хүргэсэн тухай өгүүлжээ.

Эртний монголчуудын эхнэр авах ёс заншлын тухай Монголын нууц товчоонд гарах *авлин эм, барьж авсан эм, бэргэн эм* гэх мэт холбоо үгийн утга болон тэдгээрийн утгад агуулагдах хэлний бус баримт, бусад үйл явдлаас тодруулж болно. Монголын нууц товчоонд өгүүлснээр эртний монголчуудын дунд хүүдээ охин гуйж эхнэр болгон авах ёс байсан ба ийм эхнэрийг “авлин эм” гэж нэрлэх ажээ. Энэ тухай

-Хори түмэдийн Хорилардай мэргэний охин Ариг усун-аа төрсөн Алангоо-ыг тэнд гуйж Добун мэргэний авсан ёсон тийм [9§]

хэмээн өгүүлсэн байдаг.

Түүнчлэн Есүхэй баатар Тэмүжинийг есөн настай байхад нь нагац нараас нь Олхунуд иргэнээс охин гуйхаар явдаг. Замдаа Хонгирадын Дэй сэцэнтэй тааралдаж, тэд харилцан хэлэлцэж худ ураг болохоор тохиролцдог. Өөрөөр хэлбэл, үүнд эртний монголчуудын “сүй тавих” ёсны тухай өгүүлсэн ба бага насанд нь хоёр хүүхдээ ураг барилдуулахаар эцэг эх нь харилцан тохирдог ёс байсныг, ингэхдээ ээжээр нь шинжин нагацын талаас охин гуйдаг байжээ. Ингэж сүй тавьж эсвэл гуйж авсан анхны эхнэрийг “авлин эм” гэдэг. Авлин эмээс төрсөн хүүхдүүд бусад эхнэрийн хүүхдээс байр суурь илүү, эцгийн хөрөнгө, эрх мэдлийг залгамжлан авах эрхтэй байв. Тиймээс Монголын нууц

товчоонд зөвхөн Бөртэ үжинээс гарсан дөрвөн хөвүүдийн хэн нь хаан ор залгах тухай ярилцдаг.

Харин Өгэлүн үжин Есүхэй баатарын “авлин эм” байсангүй. Түүнийг Мэргидийн Их чилэдү-ээс булааж авсан тухай зохиолын 54-56-р зүйлд тодорхой өгүүлдэг. Есүхэй баатарын анхны эхнэр (Сочигэл)-ийн тухай Монголын нууц товчоонд огт дурддаггүй. Харин Монголын нууц товчооны хожуу үеийн хувилбар болох “*Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой*” зохиолд дурдсанаар бид мэддэг.

Ийнхүү Монголын нууц товчоонд Есүхэй баатарын анхны эхнэрийн тухай огт өгүүлдэггүй нь зохиолын зорилготой шууд холбоотой. Эзэн Чингис хааныг магтан дуулж буй учир Монголын нууц товчооны зохиогч түүний эцэг эхийн нийлсэн үнэн түүхийг гуйвуулалгүй, эерүүлэн бичихийг хичээх нь зүй ёсны билээ. Иймээс зохиолын 56-р зүйлд “*Өгэлүн үжинийг Есүхэйн авчирсан ёсон тийм*” гэж тодорхойлжээ. Тодруулбал, Добун мэргэн Алангоо-ыг “*авсан ёсон тийм*” гэсэн бол Есүхэй баатар Өгэлүн үжинийг “*авчирсан ёсон тийм*” хэмээн ялган бичжээ. Өөрөөр хэлбэл, Добун мэргэн Алан гоо-ыг авсан бол, Есүхэй баатар Өгэлүн үжинийг авчирсан байна. Иймд Өгэлүн үжин “авлин эм” биш учир Есүхэй баатрыг нас барахад түүний албат харьяатууд Өгэлүн үжин болон түүний үр хүүхдийг тоолгүй хаяж явцагасан ажээ.

“Охин гуйх ёс”-той холбоотой өөр нэг зан үйл бол “хүргэдээ талбих ёс” юм. “Хүргэдээ талбих” гэдэг нь ямар нэг айлын охиныг авахаар газар газраас хүргэд ирж, тэдний дундаас хэн нэгнийг шилж сонгон хүргэн болгодог байсан учир “хүргэд” гэж олны утгаар тэмдэглэжээ. Иймээс Монголын нууц товчооны “хүргэдээ талбиж од” гэдэг хэллэгийн анхны санаа нь “хүргэн болгон орхи” гэсэн үг бус “*хүргэн болгохын тулд хүргэдийн дунд үлдээ*” гэсэн утгатай (Нарантуяа, 2020: 104-111) байжээ. Гэвч Есүхэй баатар Дэй сэцэний охиныг гуйхаар бус, Олхонуд иргэнээс охин гуйхаар явж байсныг зохиолд тодорхой өгүүлдэг. Мөн зохиолын үйл явдлаас үзвэл Дэй сэцэнийд ч охиныг нь гуйхаар газар газраас хүргэд ирээгүй байсан Дэй сэцэний зүүд совин тэдний ирэхийг зөгнөсөн, мөн Тэмүжин, Бөртэ үжин нар хоёр эцгийн санаанд нийцсэн учир сүй тавьж ураг барилдахаар тохирсон ба Есүхэй баатар Дэй сэцэнийд хүүгээ “хүргэдээ талбиж” орхиод, хөтөл морио бэлэг болгон өгдөг. Өөрөөр хэлбэл, Есүхэй баатар Дэй сэцэнийд очиж охин гуйхаар яваагүй мөн Дэй сэцэнийд охиныг нь гуйхаар газар газраас хүргэд ирээгүй байсан ч тэд уламжлалт дэг соёлоо даган Есүхэй баатар хүүгээ үлдээж явсан байна. Үүнээс үзвэл энэхүү “хүргэдээ талбих” ёс нь дундад зууны монголчуудын ураг хурмын чухал зан үйл байжээ. Түүнчлэн энэ хэсэгт эртний монголчуудын “бэлэг өгөх ёс”-ны дурдсан байна.

Мөн Монголын нууц товчоонд өөр нэгэн эхнэр буюу “барьж авсан эм”-ийн тухай

-Тэр эм бас Бодончараас нэгэн хөвүүн төрүүлби. Барьж авсан эм бүлгээ хэмээн тэр хөвүүнийг Бааридай нэрийдэв. Баарины өвөг тэр болов [41§].

гэж өгүүлдэг. Чухам яагаад ингэж нэрлэх болсон учрыг

-Бодончар алгинч уулж думд хэвэлтэй эмийг барьж “Юужин хүмүүн чи” хэмээн асуув. Тэр эм өгүүлрүүн: -Жарчиуд Аданхан Урианхажин би хэмээв [38§].

-Тэр думд хэвэлтэй эм Бодончарт ирж хөвүүн төрби. Жад иргэний хөвүүн бүлгээ хэмээн Жадарадай [Jadaradai] нэрийдэв. Жадараны өвөг тэр болов [40§].

гэсэн нь эртний монголчуудын дунд харж хамгаалах хүнгүй эмэгтэйчүүдийг авчран эхнэрээ болгох ёс байсныг илтгэж байна. Энэ нь нэг талаар ураг барилдах ёсны баримт боловч нөгөө талаар эх хүүхдийн амь насыг аврах, харж хамгаалах хүнлэг үйлдэл байв.

Монголын нууц товчоонд тэмдэглэснээр эртний монголчуудын ураг барилдах ёс заншилд бас нэг зүйлийн эхнэр болгох ёсон байжээ. Энэ тухай

-Чарахай линху-ын бэргэн эмдээс төрсөн Бэсүдэй нэрт бүлгээ.

Бэсүд овогтон тэд болов [47§].

гэж өгүүлсэн байдаг. Бэргэн эм гэдэг нь нас нөгчсөн ахынхаа эхнэртэй залган суудаг нүүдэлчдийн өвөрмөц заншлаас үүдсэн нэр юм. Ингэснээр өөрийн удмын хүн (үр хүүхэд)-ийг харьд алдахгүй, эд хөрөнгийг нь хамгаалж, бэлэвсэн эхнэр, өнчин хүүхдүүдийг боол болох аюулаас авардаг байжээ (Пунсаг, 2011: 143-144).

Мөн Монголын нууц товчоонд Бодончар Хабичи баатарын эхийн инжинд ирсэн нэгэн эмийг татаж эхнэрээ болгосон тухай

-Бодончарын авлин эмдээс төрсөн Барим шигирату хабачи нэрт бүлгээ. Тэр Хабичи баатарын эхийн инж ирснийг Бодончар татаж бүлгээ [43§].

гэжээ. Үүнээс “Татаж бүлгээ” гэдэг нь “татвар эм болгох” гэсэн утгатай юм. Монголын нууц товчоонд дурдсан эдгээр баримт нь дундад зууны нийгэмд язгууртан, баян хүмүүс олон эхнэртэй байж болдгийг харуулсан мэт боловч нөгөө талаас нийгмийн болоод амьдралын нөхцөл байдал сайтай хүн өөрөөр хэлбэл, тэжээн тэтгэх чадалтай хүн олон эхнэр авдаг, энэ нь эргээд хүн амын нөхөн үржихүйд сайнаар нөлөөлдөг заншил байсан гэж хэлж болно.

Энэ мэтчилэн Монголын нууц товчоонд тэмдэглэснээр дундад зууны монголчууд “*охин хүмүүний заяан төрсөн үүдэнд өтлөх үгүй*” гэж үзэх учир ураг хуримын хэргийг ихэд чухалчилдаг байсны баримт болж ураг барилдах олон заншлын тухай тэмдэглэжээ. Үүнд:

1. Нас бие гүйцсэн зүс царай, бие бялдар сайн эмэгтэйчүүдийг шинжин сонгож бэр гуйн ураг барилддаг ёсон байв. Тухайлбал, Добун мэргэн Алан гоо-ыг авсан түүхэнд Дува сохор ах нь, нэгэн харуутай тэрэгний өлжигт сууж бүхүй нэгэн сайн охиныг үзэж хүмүүнээ эс өгтсөн бөгөөс дүүдээ гуйх хэмээн Добун мэргэн дүүгээ илгээдэг. Добун мэргэн тэд иргэнд хүрвээс үнэн-хүү гоо сайн алдар нэр ихтэй Алангоо нэртэй хүмүүнээ бээр өгтөөгүй охин байсан учир Алангоо-ыг тэнд гуйж Добун мэргэн авсан гэдэг. Ингэж охин гуйж ураг

барилдах ёсон одоо хүртэл хадгалагдсаар байгаа монголчуудын эртний заншил юм. Үүнээс гадна дурдсан хэсэгт нөхөрт гараагүй залуу охидыг тэрэгний урд ил суудалд суулгадаг тухай өгүүлсэн байх бөгөөд нөхөрт гарсан эмэгтэйг тэрэгний бүхээгт суулгадаг заншилтай байжээ. Иймээс

-Өлжиг тутам охид

Харуу тутам хатад буй [55§]

гэдэг хэллэг үүсжээ. Тухайлбал, Есүхэй баатар Өгэлүн үжинтэй тааралдсан тухай

-Тэр цагт Есүхэй баатар Онон мөрөнөө шувуулан явахуйд Мэргидийн Их чилэдү Олхунуд иргэнээс охин авч үүсгэж айсухыг золгож, өнгийж үзвээс өнгө зүс бустай охин хатан үзэж гэртээ харин уулж, Нэхүн тайш ах юугаа Дааридай отчигин дүүгээ удирдаж иржүхүй [54§].

гэсэн нь Өгэлүн үжин хүний эхнэр болсон тул тэргэн дотор сууж явсныг Есүхэй баатар “*өнгийж үзсэн*” байна. Хэрэв тэрэгний өлжигт суудалд ил сууж явсан бол өнгийх учир гарахгүй биз ээ.

2. Эртний монголчуудын дунд охин гуйх өөр нэгэн ёс байв. Энэ нь хүүгээ юмны учир мэддэг болж ухаан төхөө ормогц дагуулан явж эхийн төрхмөөс “охин гуйж” сүй тавих ёс юм. Ингэж сүй тавьж ураг барилдахыг харилцан зөвшөөрвөл (“зэ” бололцох) хүүгээ “хүргэдээ талбин” үлдээж, бэлэг өгдөг байжээ. Эцэг эхийн хийсэн ийм аман тохиролцоо, ямар нэгэн шалтгаанаар цуцлагдаагүй бол хэзээд хүчинтэй байж, сүй тавьсан залуус гэрлэдэг байна. Үүний жишээ нь, Есүхэй баатар Дэй сэцэнийд хүүгээ “хүргэдээ талбин” үлдээн гэртээ харих замдаа Татаруудад хорлогдон бие барсан боловч Тэмүжин хожим Дэй сэцэнийд очиж Бөртэ үжинтэй нийлсэн түүх билээ.

3. Мөн эртний монголчуудын дунд охиноо арилжин өгч худ ураг болох ёсон байв. Энэ тухай

-“Амраг дээр давхар амраг болъё” хэмээн Чингис хаан сэтгэж

Жочи-д Сэнгүмийн дүй Чагур бэхийг гуйруун, Сэнгүмийн хөвүүн

Тусаха-д бидний Хожин бэхийг арилжин өгъе хэмээн гуйваас [165§]

гэж өгүүлснээс үзвэл “амраг дээр давхар амраг болох” буюу илүү ойртон нөхөрлөж, харилцаа холбоогоо бататгах зорилгоор охиноо арилжин (солилцон) өгч ураг барилддаг байжээ. Өөрөөр хэлбэл, энэ бол нэг төрлийн улс төрийн зорилготой гэрлэлт юм. Хэрэв хоёр тал харилцан тохиролцвол “бугулзар идээр ирэгтүн” хэмээн урьж хуримлан найрладаг байжээ. Энэ нь нэг зүйл ураг барилдсаны тангараг хурим юм. Ингэж ураг барилдахад бугулзар иддэгийн учир нь

-Бугулзар нь хоёр зүйлийг холбодог учир ураг барилдаж буй хоёр хүний нэг насны амьдралаа холбох ургийн болзоог илэрхийлдэг,

-Мөн арга билгийн буюу эр эмийн бэлгэдлийг илэрхийлдэг,

-Гэр бүл бат бөх байхыг бэлгэддэг,

-Монголчуудын ангийн зан үйлтэй холбогдвол амьтны хүзүү бугулзарт

тухайн амьтны сүнс сүлд оршдог хэмээн үзэж, амин сүнсний бэлгэдэл тус тус болгодог байжээ.

4. Түүнчлэн охиноо нэр заан өгч улс төрийн шинжтэй ураг барилдах ёсон байв. Түүхэнд тэмдэглэснээр Чингис хаан өөрийн охидыг ингэж нэр заан өгч хуримлуулсан гэдэг бөгөөд түүний охид хаан эцгийнхээ үйл хэрэгт тусалж Монголын эзэнт гүрэн хүчирхэгжин мандахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэдэг. Тухайлбал, Ал алтун гүнжийн хүчин чармайлтаар Торгоны замд хяналт тавьж, өөрсдөдөө давуу байдлыг бий болгож байсан гэдэг. Тэр цагт их хааны охидтой хуримлах нь нэр хүндийн хэрэг байсан бөгөөд тийм хүргэд бага хатан авах эрхгүй байв. Ийм жишээг дурдвал

-Ойрадын Худуга бэхи-ийг угтан элсэн түмэн ойрадоо удирдан ирэв хэмээн соёрхож хөвүүнээ инү Иналчи-д Чэчэйхэнийг өгөв. Иналчи-ын ах Төрөлчи-д Жочи-ын охин Холуйханыг өгөв. Алаха бэхи-ийг Өнгүдэд өгөв [239§].

гэх мэт. Ингэж улс төрийн зорилгоор охид хатдынхаа өнгө зүсээр явж ирсэн хүмүүс бол Хонгирад иргэн юм. Монголын нууц товчоонд өгүүлснээр Хонгирад иргэн бол бусад иргэнтэй эсэргүүцэн тэмцэлдэх хүсэлгүй, өөрийн охид хатад өнгө зүсээр хаад ноёдтой ураглан, тэдний айлтгал мэдүүлгээр хэргээ бүтээдэг гэж өгүүлсэн байна. Ингэж улс төрийн зорилготой ураг барилдах ёс дундад зууны монголчуудын дунд түгээмэл байсны бас нэгэн жишээ нь Увас мэргидийн Дайр усун өөрийн охин Хулан хатныг дагуулан ирж Чингис хаанд өгсөн түүх билээ.

5. Уулгалан довтолсон иргэний охид хатдыг олзлон авчирч, дайны олз хэмээн хуваан авах ёс байв. Тухайлбал,

-Тэдүй Хэрэйд иргэн доройтуулж зүг зүг хувааж талуулбай. Сүлдүдэй Тахай баатарын тусын ину тул нэгэн зуун Жирхинийг өгөв. Бас Чингис хаан зарлиг болруун, Ван ханы дүү Жаха гамбу жирин охид ажгуй. Эгчмэд инү Ибаха бэхийг Чингис хаан өөсөн (өөрөө) авруун, дүймэд Сорхагтани бэхийг Толуйяа өгөв [186§].

гэж өгүүлэхээс гадна Найманыг мохотгон барж Таян ханы эх Гүрбэсү-ийг барьж авчран Чингис хаан өөртөө авсан, Мэргид иргэнийг дайлж Тогтога бэхийн их хөвүүн Хуту-ын хатад Түгэй Дөрэгэнэ жирнээс Дөрэгэнэ-ийг Өгэдэй хаанд өгөв гэх мэтээр өгүүлсэн байдаг. Ингэж ураг барилдах нь нэг талаар дайн тулааны хэрэгт охид хатдыг буруутгалгүй амьд үлдээн хэн нэгний асрамжид өгч байгаа бол нөгөө талаар дайнд ялсан, ялагдсан хоёр тал өс хонзон санах, үндэс угсаа, ураг төрлөөр нь гадуурхах зэрэг элдэв зөрчилгүй, амар тайван аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой байв.

6. Мөн язгууртан дээдсийн зүгээс дайнд гавьяа байгуулсан хүмүүст өөрийн татвар эмийг эхнэр болгон өгөх ёсон байв. Тухайлбал, Жүрчэдэйн байгуулсан гавьяаг үнэлж Чингис хаан өөрийн татвар эхнэр Ибаха бэхийг түүнд өгсөн явдал юм. Үүнээс үзвэл татвар эмийн байр суурь тийм ч баттай бус, нөлөө багатай байжээ.

Монголын нууц товчоон дахь шашин шүтлэгийн соёл. Эртний хүмүүс байгаль дэлхийн элдэв үзэгдлийн учрыг шалтгааныг тайлж мэдэхгүй тул түүнээс айж, түүнийг бурханчлан үздэг байв. Гэвч нүүдэлчдийн амьдралын хэв маяг нь тэднийг байгаль дэлхийтэй нь ойр байлгаж, тэдний оршин тогтнох үндэс гэдгийг ухааруулсан байдаг. Тиймээс тэд байгалийг таних мэдлэг, тэнгэрийг унших эрдэмтэй болсон бөгөөд үүний тул байгаль дэлхийгээ аргадан тайх бөө мөргөлийн шашинтай болсон байна. Нүүдэлчин малчид өдөр тутмын ахуй амьдралын дадал зуршлаараа байгаль дэлхийн ааш араншныг таних, тэнгэрийг унших эрдэмтэй болдог бол бөө заарингууд тэнгэртэй харьцаж тэнгэрийн хэлийг уншиж ойлгон, түүний хүсэл тааллыг дамжуулагчид юм. Баримтаас үзвэл, эртний хүмүүс анхандаа байгалийн хүчинд автан айн зүрхшээдэг байсан бол яваандаа учрыг нь олохыг эрмэлзэх болж, бага багаар танин мэдэж, байгалийн элдэв үзэгдлийг аргалан өнгөрөөх мэдлэг, туршлагатай болжээ. Ингэснээр анхны мухар сохор айдас нь үгүй болохын цагт байгаль дэлхийн тогтоц, бэлэн зүйлийг өөрт ашигтайгаар хувиргах, тэр бүү хэл нийгмийн амьдралд бусдад нөлөөлөх хүч болгон ашиглаж эхэлжээ. Тиймээс байгалийн гаж сонин үзэгдэл, онцгой мод, чулуу зэргийг тэнгэрийн дохио тэмдэг дамжуулах хэрэгсэл гэж үзэн байгалийг аргадах, тахих зан үйлд ашиглаж байв. Үүний тодорхой жишээ нь Монголын нууц товчоонд гарах саглагар модон орчин дэвсэн бүжих зан үйл юм. Ийнхүү байгаль дэлхий буюу тэнгэр газар, наран сар, амьтан ургамал, хад чулуу, уул усыг хүншүүлэн үзэж амьдчилан тахих зан үйлтэй болсноор бусдыг өөртөө татах хүч нөлөө улам ихэссэн байна. Ийм хүмүүс бол бөө, зайрангууд юм.

Дундад зууны монголчуудын ойлголтоор “Тэнгэр” нь “Хүний орчлонгийн дээр оршиж, бүхнийг мэдэж захирах агуу их хүч” агаад гагцхүү зайран бөөгөөр дамжуулан онгон сахиусны дүрээр хааяа илрэн өөрийн санаа зорилгоо мэдүүлдэг учир түүний үг дамжуулагчийг “тэнгэрийн зайран” [tenggeri-yin ja’arin 206§] хэмээн нэрлэдэг ажээ. Яваандаа хүмүүсийн танин мэдэхүйн чадвар нэмэгдэхийн хэрээр бөө, зайрангууд зөвхөн байгаль дэлхийн бэлэн юмсыг ашиглахаа больж, элдэв содон сонин арга эрэлхийлэх болов. Монголын нууц товчоонд өгүүлснээр бөө нар бас тэнгэрийн дохио тэмдгийг мэдэхийн тулд мал амьтны гэдэс дотроор шинждэг байжээ. Бөөгийн зан үйлд хэрэглэх ийм тахилын амьтны гэдэс дотрыг авид [12§] гэх ба ингэж гэдэс дотроор шинжин мэргэлэхийг “авидлах” [272§] гэдэг байв. Энэ үед бөөгийн тахилын үйл, онгод сахиусаа дуудах зэрэг зан үйлийг ерөнхийд нь “зүхэл” гэж нэрлэн ийм зан үйлд оролцохыг “зүхэлд орох” [43§], оролцохыг болиулбал “зүхэлдээс гаргах” [44§] гэж хэлдэг. Ингэж зүхэл тайлгын үеэр бөө нарын зүхэрсэн усыг “зүхэргэн ус” [272§] гэж нэрлэнэ. Монголын нууц товчооны 143-р зүйлд дурдсан баримтаас үзвэл, дундад зууны монголчууд байгаль дэлхийгээ аргадан харьцаж сурсан төдийгүй байгалийн элдэв үзэгдлийг удирдах, өөрт ашигтайгаар өөрчлөх, тайлбарлах зэргээр оролдох болсон нь тэдний ертөнцийг танин мэдэх туршлага нэмэгдсэн буйг харуулдаг.

Монголын нууц товчооны баримтаас үзвэл эртний монголчуудын шашин шүтлэг, түүнийг илэрхийлэх зан үйлд байгаль газар зүйн онцлог их нөлөөтэй.

Өөрөөр хэлбэл, энэ үед шашин байгаль дэлхийтэйгээ харьцах харьцаанд тулгуурлаж байсан бол, хүний танин мэдэхүй, мэдлэг, туршлага нэмэгдэхийг дагалдан хийсвэрлэх, бясалгах шинж нь давамгайлах болжээ. Энэ нь бөө мөргөлийн зан үйлээр илэрнэ. Тухайлбал, нэгэнт учрыг тайлж мэдэхгүй, даван туулах хүч мөхөс, удирдан жолоодож чадахгүй учир тэд байгалийг хүншүүлэн үзэж аргадан гуйх, тахин шүтэх зэргээр хүндэтгэлтэй ханддаг байв. Энэ тухай Монголын нууц товчоонд

-Тэнгэр дээр наран сар хоёр гэрэлтэн гэгээн болтугай хэмээн наран сар хоёр буй зэ. Газар дээр хоёр хад хэр болох [189§].

хэмээн өгүүлсэн нь тэнгэрт наран сар хоёр байж болно, учир нь наран сарны гэрлээр энэ дэлхий гэрэлтэн, амьдрал цэцэглэж буй. Харин газар дээр хоёр хан байж болохгүй, учир нь амар тайван амьдрах аргагүй гэжээ. Энэ нь тэнгэр газар, наран сарны эрхшээлд хүмүүн төрөлхтөн амьдардаг, наран саргүй бол энэ дэлхийд амьдрал үгүй гэдгийг илэрхийлсэн утгатай. Улмаар тэнгэр нь хүрч үл чадах өндөрт орших учир дээдийн дээд, агуу хүчний орших орон бол газар нь хүн, амьтан, ургамлын шим тэжээлийн уг сурвалж, оршин тогтнолын үндэс учир төрүүлсэн эх адил дотночлон хандана. Хүн гэдэг амьтан мод ургамал, ан амьтны нэгэн адил газрыг шүтэж амьдрах тул өөрсдийгөө тэдэнтэй адилтган үзэж байгаль дэлхийн юмсыг хүншүүлэн сэтгэнэ. Ийм үзэл хандлагаас өөрийн оршин тогтнолын үндэс болсон байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах санаа сэдэл үүснэ. Иймээс эртний монголчуудын шашин шүтлэг нь мухар сүсгийн бус байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах арга, нүүдэлчдийн танин мэдэхүйн ойлголттой холбоотой ажээ. Ерөөс шашин шүтлэг үндэстний ухамсрын бэлгэдэл болдог учир бусад ард түмнээс ялгарах нэгэн шинж болдог. Иймээс бөө мөргөлийг байгалийн шашин гэж нэрлэдэг. Шашин шүтлэг нь хүн болон нийгмийн мөн чанар бүрэлдэн тогтоход оролцож, амьдралынх нь хэв маягийг тодорхойлж, ард түмний соёлын чухал бүрдүүлбэр болдог (Нансалмаа, 2019: 271). Өөрөөр хэлбэл, эртнээс нааш шашин шүтлэг нь үндэстний соёлд нөлөөлөх гол хүчин байж, ард түмний ухамсар сэтгэхүйд гүн гүнзгий шингэсэн байдаг. Тийм учраас Чингис хаан монгол овог угсаатныг хураан цуглуулах үйл хэрэгт шашны нөлөөг ашиглахаар шийдэж Хорчи-ын дэмжлэгийг авчээ. Түүнээс өмнө XIII зуун хүртэл бөө мөргөл нь онгод тэнгэр, шашны зан үйлийн хувьд хараахан нэгдэн төлөвшөөгүй, овог аймаг, орон нутгийн шинжтэй эртний байгалийн шашин байв. Харин улс төрийн хувьд нэгдэж, нэг үндэстэн болж хүчирхэгжихийн цагт итгэл үнэмшил, үзэл ухамсрын хувьд нэгдэх шаардлага гарч энэ нь шашны сэтгэлгээнд биеллээ олсон билээ. Өөрөөр хэлбэл, эзэн Чингис хаан эртний монголчуудын “дээр тэнгэр”, “тэнгэр газар” гэсэн бөө мөргөлийн ойлголтод суурилсан шашны сэтгэлгээнд “Мөнх тэнгэр” гэсэн шинэ ойлголт ухагдахууныг суулган төлөвшүүлжээ. Энэ цагаас эхлэн овог аймгийн хүрээнд байсан өөр өөрсдийн шүтлэг бүхий уулс ус, сүнс онгодын залбирлыг Мөнх тэнгэрийн шүтээнээр нэгтгэсэн нь монголчууд ухамсар сэтгэхүй, үзэл бодлын хувьд нэгдэн нийлэх үндэс болсон юм. Энэ бол зөвхөн шашин шүтлэгийн хувьд гарсан өөрчлөлт бус дундад зууны монголчуудын сэтгэлгээнд гарсан том өөрчлөлт байв. Үүнээс үзвэл бөө мөргөл бол овог аймгийн шүтлэг бишрэл,

харин мөнх тэнгэр бол улс үндэстний шашин юм. Тодруулбал, Чингис хаан олон мянган жилийн уламжлалтай байгалиа шүтсэн бөө мөргөлийн соёлд шинэчлэлт хийж Мөнх тэнгэрийн шашныг үүсгэсэн байна. Өөрөөр хэлбэл, “Саглагар мод”-ыг шүтэн тойрон дэвсэж (бөө мөргөлтэй) байсан хүмүүс “Есөн цагаан тугаа байгуулан” “Мөнх тэнгэр”-ийг шүтэх болсон байна. Ийнхүү дундад зууны монголчуудын ухамсар сэтгэлгээнд Мөнх тэнгэрийг тахиx үзэл батад сууснаар оюун санааны хувьд нэгдэн нягтарч чадсан учир Чингис хааны монгол овог аймгаа хураан цуглуулах үйл хэрэг нь бусад улс үндэстнийг дайлан эзлэх дэлхийн хэмжээний түүхэн хэрэг явдал болон өргөжихөд чухал нөлөө үзүүлсэн гэж хэлж болно.

Дүгнэлт

Бидний хийсэн судалгаанаас үзвэл эртний монголчуудын бүтээн бий болгосон соёл, ёс заншил нь эртнээс нааш уламжлагдан ирж, нийгмийн харилцааг эмх цэгцтэй, дэг журамтай болгодог бичигдээгүй журам байжээ. Өөрөөр хэлбэл, эртний монголчуудын соёлоор дамжсан дадал зуршил нь нийгмийн амьдрал болоод өдөр тутмын ахуй амьдралыг эмх журамтай болгож, тэрхүү өдөр тутмын амьдралын дадал хэвшлээр дамжуулан хүнийг хүмүүжүүлэн төлөвшүүлэх, ёс суртахуун, харилцааны хандлагад сургадаг, товчоор хэлбэл хүнийг “хүн” болгодог гол зүйл байжээ.

Ном зүй

Монгол хэлээр:

Нансалмаа, Н. (2015) *Үгийн сан судлал* Улаанбаатар: МУИС пресс. [Nansalmaa, N. Ugiin san sudlal [Lexicology] Ulaanbaatar, MUIS press. 2015.]

Хэниш, Э. (1939) *Монголын нууц товчоо* Весбаден [Haenisch. E., “Wörterbuch zu Manghul-un niuca tobca'an” Weisbaden, 1939.]

Нарантуяа, Р (2020) *Монголын нууц товчоонд “хүргэдтээ талбих” ёс заншил тэмдэглэгдсэн тухай* -Монголын нууц товчоон судлалын өгүүллийн түүвэр Улаанбаатар: Жиком пресс [Narantuya. R., “The tradition of “leaving the betrothed in the house of in-laws” documented in the Secret History of the Mongols” -A Collection of Articles on the Study of The Secret History of the Mongols. Ulaanbaatar. 2020]

Пунсаг, А. (2011) *Монголын нууц товчоон дахь ёс заншлын судалгаа* Улаанбаатар: Бэмби сан [Punsag, A. Mongoliin nuuts товчоон dahi yos zanshliin sudalgaa [A Collection of Articles on the Study of The Secret History of the Mongols] Ulaanbaatar. 2011.]

Нансалмаа, Н. (2019) *Нийгэм хэл шинжлэл* Улаанбаатар: МУИС пресс. [Nansalmaa, N. Niigem hel shinjlel [Social linguistics] Ulaanbaatar, MUIS press. 2019.]

Мөнхсайхан, С. (2024) *Монголын нууц товчоо эрдэм шинжилгээний хөрвүүлэг* Улаанбаатар: Соёмбо принтинг. [Munkhsaikhan, S. Mongoliin nuuts tovchoo [The Secret History of the Mongols Academic transcription] Ulaanbaatar. 2024.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.

ОРЧУУЛГА